



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 15 өдөр

Дугаар 1/688

Булган сум

**Түгээмэл тархацтай ашигт малтмалын
ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.2 дахь заалт, 19.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орхон сумын "Хүрмэн-1" нэртэй газрын 30.77 гектар талбайд Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицлыг хавсралт хүснэгтийн дагуу 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 15 жилийн хугацаатайгаар "Евро базальт" ХХК-д олгосугай.

2. Холбогдох хууль тогтоомж, журмын хүрээнд үйл ажиллагаа явуулахыг Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Евро базальт" ХХК (С.Бат-Өлзий)-д үүрэг болгосугай.

3. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд холбогдох хуулийн дагуу хяналт тавьж, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Давааням), Байгаль орчны газар (А.Гантөмөр), Газрын харилцаа, Барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн), Татварын газар (Д.Лхагвасүрэн), Орхон сумын Засаг дарга (Н.Амартүвшин) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны А/68 дугаар "Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай" захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ



6324010965

Аймгийн Засаг даргын 2024 оны 10
дугаар сарын 15-ны нийгдрийн А/698
дугаар/дүгээр захирамжийн хавсралт

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН
АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОЖ БУЙ
АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭР, ГАЗРЫН ХЭМЖЭЭ, БАЙРШИЛ

№	Хуулийн этгээдийн нэг	Ашиглалт хийх газрын нэр	Ашиглалт -ын талбайн хэмжээ /га/	Талбайн байршил						
				№	Уртраг			Өргөрөг		
					град	мин	сек	гра д	мин	сек
1	"Евро базальт" ХХК	Орхон "Хүрмэн- 1"	30.77	1	103	34	55.54	48	40	47.23
				2	103	34	54.15	48	40	47.24
				3	103	34	34.7	48	40	47.24
				4	103	34	34.7	48	40	28
				5	103	34	40.84	48	40	28
				6	103	34	40.84	48	40	21.88
				7	103	34	55.25	48	40	21.88
				8	103	34	55.54	48	40	47.23